БЛАСТ ХХК

Тэсрэх бодисын үйлдвэрлэл, тэсэлгээний ажил үйлчилгээ

www.blastcompany.mn

MACK

БИДНИЙ ТУХАЙ

Бласт ХХК нь 2001 онд үүсгэн байгуулагдсан, тэсэлгээний салбарт Монгол улсдаа анхдагчдын нэг, үндэсний үйлдвэрлэгч, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний компани юм.

Манай хамт олон хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг хангасан, олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг чанарын өндөр түвшинд, найдвартай, шуурхай хүргэн ажилладаг.

Бид 2011 онд олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2008, MNS ISO 9001:2010 стандартыг байгууллагын үйл ажиллагаандаа нэвтрүүлж, 2018 оноос чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, MNS ISO 9001:2016 стандартад шилжин, мөрдөн ажиллаж байна.

Бид байгууллагын үйл ажиллагаанд дараах стандартуудыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн менежментийн тогтолцоо MNS ISO 45001:2018
2. Байгаль орчны менежментийн тогтолцоо MNS ISO 14001:2016

Үйл ажиллагааны чиглэл

- Тэсрэх бодисын үйлдвэрлэл
- Тэсэлгээний ажил үйлчилгээ
- Тэсрэх материал, түүхий эдийн сорилт, судалгаа
- Тэсрэх материалын импорт, худалдаа
- Үйлдвэр, агуулахын зураг төсөл боловсруулах, барьж байгуулах
- Тэсрэх материал, химийн бодисын тээвэрлэлт

EP14

ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Бид уул уурхайн салбарын хурдацтай хөгжилтэй уялдуулан тоног төхөөрөмж, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангасан чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.

“Бласт” ХХК нь бүрэн автомат удирдлагын системтэй, аюулгүй ажиллагааг хангасан үйлдвэрт дараах нэр төрлийн тэсрэх бодисуудыг үйлдвэрлэдэг.

- Задгай эмульсийн тэсрэх бодис
- Задгай энгийн тэсрэх бодис
- Савлагаат эмульсийн тэсрэх бодис
- Энгийн тэсрэх бодис
- Хүчитгэсэн энгийн тэсрэх бодис

ЗАДГАЙ ТЕХНОЛОГИЙН ТЭСРЭХ БОДИС

Задгай технологийн тэсрэх бодис нь тусгай зориулалтын цооног цэнэглэгч автомашинаар тээвэрлэн, богино хугацаанд хялбар цэнэглэдэг тул бүтээмж өндөртэй, аюулгүй ажиллагааг хангасан байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн юм. Бид дараах нэр төрлийн задгай технологийн тэсрэх бодисуудыг үйлдвэрлэн, хэрэглэгчдэд нийлүүлж байна.

Үүнд:

- Задгай эмульсийн тэсрэх бодис /BLEMEX BULK & BLEMEX BLEND/
- Энгийн тэсрэх бодис /ANFO/

Техник, шинж чанарын үзүүлэлт:

Үзүүлэлт	Задгай эмульсийн тэсрэх бодис		Энгийн тэсрэх бодис
	BLEMEX BULK	BLEMEX BLEND	ANFO
Тэсрэлтийн хурд (м/с)	3600-5200	3800-5800	2500-3400
Мэдрэг чадвар	Өдөөгч 500гр-аас дээш	Өдөөгч 500гр-аас дээш	Өдөөгч 300гр-аас дээш
Тэсрэлт авах туйлын бага диаметр (мм)	90	90	75
Нягт (гр/см^3)	1.11-1.25	1.11-1.25	0.82-0.85
Хэрэглэх нөхцөл	Устай ба усгүйжүүлсэн цооног		Хуурай цооног

ЗАДГАЙ ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС /BLEMEX BULK/

Задгай эмульсийн тэсрэх бодис Blemex Bulk -ийг цооногт цэнэглэлт хийсний дараа тэсрэх бодис болдог тул аюулгүй ажиллагаа хангасан бүтээгдэхүүн юм. Бид АНУ-ын технологийн үйлдвэрийг уурхайн дэргэд барьж ил уурхайн устай болон хуурай цооногт тэсэлгээний ажил явуулж байна. Энэхүү тэсрэх бодисыг уурхайн уул геологийн онцлогт нийцүүлэн тэсрэлтийн хүч, хурд зэргийг тохируулан ашиглах боломжтой байдаг.

ЗАДГАЙ ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС /BLEMEX BLEND/

Бид задгай эмульсийн тэсрэх бодис Blemex Bulk -д хүч нэмэгдүүлэх хольцыг хийж, тэсрэлтийн хурд, хүчийг нэмэгдүүлсэн Blemex Blend төрлийн тэсрэх бодисыг үйлдвэрлэж байна. Уурхайн онцлог нөхцөлд тохируулан хатуулаг өндөртэй чулуулагт хүч нэмэгдүүлсэн задгай эмульсийн тэсрэх бодисыг ашиглах нь тохиромжтой байдаг.

ЭНГИЙН ТЭСРЭХ БОДИС /ANFO/

Бид монгол улсын MNS 4223:94 стандартыг хангасан энгийн тэсрэх бодисыг тусгай зориулалтын цооног цэнэглэгч машинаар ил уурхайн тэсэлгээний ажилд, хуурай цооногт хэрэглэгчдийн шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэж байна. Бүтээгдэхүүний өртөг бага, мөн цооногийг богино хугацаанд цэнэглэх тул бүтээмж өндөртэй байдаг.

САВЛАГААТАЙ ТЕХНОЛОГИЙН ТЭСРЭХ БОДИС

Савлагаатай технологийн тэсрэх бодис нь Монгол орны эрс тэс уур амьсгалтай нөхцөлд ашиглахад тохиромжтой, хадгалах хугацаа урттай бүтээдэхүүн юм. Тэсэлгээний ажлыг улирлын чанартай гүйцэтгэдэг болон тэсрэх бодисын хэрэглээ багатай хэрэглэгчид агуулахдаа нөөцлөн хэрэглэхэд тохиромжтой байдаг. Бид дараах төрлийн савлагаатай технологийн тэсрэх бодисыг үйлдвэрлэдэг.

Үүнд:

- Савлагаат эмульсийн тэсрэх бодис
- Энгийн тэсрэх бодис
- Хүчитгэсэн энгийн тэсрэх бодис

Техник, шинж чанарын үзүүлэлт:

Үзүүлэлт	Савлагаат эмульсийн тэсрэх бодис /BLEMEX PACKEGED/	Энгийн тэсрэх бодис /ANFO/	Хүчитгэсэн энгийн тэсрэх бодис /ANFO WHITH ALUMINIUM/
Тэсрэлтийн хурд (м/с)	4600-5900	2500-3400	2500-3700
Бутлах чадвар (мм)	16-20	-	-
Мэдрэг чадвар	Бялт тэслүүр	Өдөөгч 300гр-аас дээш	Өдөөгч 300гр-аас дээш
Тэсрэлт авах туйлын бага диаметр (мм)	32	75	75
Нягт (гр/см³)	1.10-1.14	0.82-0.85	0.82-0.85
Хэрэглэх цооногийн төрөл	Устай ба хуурай	Хуурай	Хуурай
Хадгалах хугацаа (хоног)	180	180	180
Савлагааны төрөл	Цаасан хайрцаг	Шуудай	Шуудай
Жин (кг)	24	25	25

САВЛАГААТ ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС /BLEMEX PACKAGED/

Савлагаат эмульсийн тэсрэх бодисыг хий тоосны аюулгүй ил болон далд уурхай, тусгай зориулалтын тэсэлгээний ажилд өргөн хэрэглэдэг. Уг бодис нь тэсрэлтийн хурд болон бутлах чадвар өндөр байдаг ба захиалагчийн сонголтын дагуу 32-220мм хүртэлх дурын диаметрээр савлан үйлдвэрлэдэг.

ЭНГИЙН БОЛОН ХҮЧИТГЭСЭН ЭНГИЙН ТЭСРЭХ БОДИС /ANFO, ANFO WITH ALUMINIUM/

Энгийн болон хүчитгэсэн энгийн тэсрэх бодисыг АНУ-д үйлдвэрлэсэн бүрэн автомат удирдлагын систем бүхий иж бүрэн суурин тоног төхөөрөмжөөр зориулалтын полиэтилен дотортой шуудайд савлан үйлдвэрлэдэг.

Мөхлөг хэлбэрийн хөнгөн цагааны хольц бүхий хүчитгэсэн энгийн тэсрэх бодис нь агаарт тоосонцор үүсгэж, цахилгаан цэнэг хуримтлуулдаггүй тул байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй ажиллагааг хангасан давуу талтай бүтээгдэхүүн юм. Энгийн тэсрэх бодистой харьцуулахад тэсрэлтийн хурд, хүчин чадал өндөр байдаг тул төмрийн хүдрийн ил уурхай, хатуулаг өндөртэй чулуулаг, улирлын хөлдүүстэй хөрсөнд хэрэглэхэд илүү тохиромжтой.

MASM
ISO
9001
CERTIFIED
BLAST COMPANY
BLAST COMPANY

БЛАСТ ХХК-ИЙН ЧАНАРЫН БОДЛОГО

Бласт компанийн чанарын бодлого нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй үйлдвэрлэл, үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд явуулж, олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээгээр хэрэглэгчдийг найдвартай хангахад оршино. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн, үйлдвэрлэл үйлчилгээний технологийн горим, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг мөрдөж, чанарын менежментийн тогтолцоо, ажлын үйл явц, зохион байгуулалт, техник технологи, ажилтны хариуцлага, мэдлэг чадварыг тасралтгүй сайжруулан ажиллана.

ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Бласт ХХК нь 2003 оноос тэсэлгээний ажил үйлчилгээг үзүүлж эхэлснээс хойш ил, далд уурхай болон бусад төрлийн тэсэлгээний ажлуудыг дэвшилтэт техник технологи, ашиглан холбогдох хууль, журмын дагуу аюулгүй хийж гүйцэтгэж байна.

Манай компани дараах төслүүдийн тэсэлгээний ажлыг гүйцэтгэсэн мэргэшсэн, туршлагатай тэсэлгээний багтай.

- “Бороо Гоулд” ХХК-ийн Их даширын алтны үндсэн орд
- “Монгол газар” ХХК-ийн Олон-Овоотын алтны үндсэн орд
- “Баян Айраг Эксплорэйшн” ХХК-ийн Баян-Айрагийн алтны үндсэн орд
- “Алтайн Хүдэр” ХХК-ийн Таян нуурын төмрийн хүдрийн уурхай
- Шарын гол, Шивээ-Овоо, Баруун Ноён-Уул, Цант-Уул, Таван толгой, Нарийн сухайтын нүүрсний орд газрууд
- Барилга, замын болон бусад тусгай зориулалтын тэсэлгээний ажлууд

ТЭСРЭХ БОДИСЫН СОРИЛТ, СУДАЛГАА

Тэсрэх бодисын сорилт судалгааны төв лаборатори нь 2008 онд анх байгуулагдан өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, түүний найрлагад ордог химийн бодист судалгаа шинжилгээ хийж эхэлсэн бөгөөд 2013 оноос хойш сорилт болон шалгалт тохируулгын лабораторийн ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандартыг хангаж, үйл ажиллагааны хүрээг нэмэгдүүлэн, дараах чиглэлийн дагуу үйлчилгээг үзүүлж байна.

СОРИЛТ ШИНЖИЛГЭЭ

Бид итгэмжлэлийн хүрээнд тэсрэх бодис, түүний түүхий эдэд үндэсний болон олон улсын стандарт арга аргачлалыг ашиглан аж ахуйн нэгж байгууллагуудад хараат бусаар сорилт шинжилгээ хийх үйлчилгээ үзүүлдэг.

Сорилт шинжилгээ болон тэсэлгээний ажилд дүн шинжилгээ хийх зорилгоор салбартаа тэргүүлэгч компаниудын тоног төхөөрөмж ашигладаг. Тухайлбал Канад улсын MREL компанийн өндөр хурдны камер, цооногийн дуран, өндөр нарийвчлал бүхий тэсрэлтийн хурд хэмжигч багажийг ашиглаж байна.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР ХЯНАЛТ

Үйлдвэрлэлийн бүх шат дамжлага болон хэрэглэгчдэд нийлүүлсэн бүтээгдэхүүний хяналтын дээжид тогтмол шинжилгээ хийж, чанар стандартад хяналт тавин ажилладаг.

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Шинэ тутам хурдацтай хөгжиж буй тус салбарт хөл нийлүүлэн орчин үеийн дэвшилтэт техник, технологи, бодис, найрлага зэргийг судлан нэвтрүүлж, нутагшуулан ажиллаж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА СОРИЛТЫН ТӨРЛҮҮД

№	Тэсрэх бодист	Түүхий эдэд
1	Тэсрэлтийн хурд	Азотын агуулга
2	Бутлах чадвар	Шингээх чадвар
3	Тэсрэлт дамжих зай	Чийглэг
4	Нягт	Мөхлөгийн бүтэц
5	Хүчилтөрөгчийн тэнцэл	Овоолгын нягт
6	Шатах хольцын хэмжээ	Уусмалын орчин (pH)

ШИЛТЭН СТАКАН
ЦИЛИНДР

ДЕТОНАТОРОВ СБОРКИ
НЕЭЛЕКТРИЧЕСКИЕ
UN 0360
DETONATOR ASSEMBLIES
NON-ELECTRIC
EXPLOSIVE
1.4S
11
B
1
АО «НМЗ «Искра»
Iskra Novosibirsk Mechanical Plant JSC
ИСКРА-С
16
5/1404-19
500
04.2019
04.2022
60

ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН ИМПОРТ, ХУДАЛДАА

Манай компани олон улсын чанарын шаардлага хангасан, Монгол улсын эрс тэс уур амьсгал, тухайн ордын уул геологийн нөхцөлд тохирсон тэсрэх материалыг, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд тогтмол нийлүүлж байна.

Хэрэглэгчдийн тэсрэх материалын сонголт болон ашиглалтад зөвлөгөө өгч тухайн төсөлд шаардлагатай тэсрэх материалыг импортлон, хамтран ажиллахад бэлэн байна.

Гадаргын холбогч

Цахилгаан бус тэслүүр

Цочир дамжуулах шижим

Цахилгаан тэслүүр

Бялт тэслүүр

Гал дамжуулах шижим

Өдөөгч



Хором удаашруулагч

ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРЬЖ БАЙГУУЛАХ

Бласт ХХК-ийн тусгай зөвшөөрөл бүхий техникийн төсөл боловсруулах мэргэжлийн баг нь тэсрэх бодисын үйлдвэр болон агуулахын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах, тооцоолол хийх, барьж байгуулах ажлын туршлагатай. Өнгөрсөн хугацаанд энгийн болон эмульсийн тэсрэх бодисын 8-н үйлдвэр, олон тооны тэсрэх материалын агуулахыг барьж улсын комисст хүлээлгэн өгсөн.

Өөрийн компанийн үйлдвэр агуулахаас гадна харилцагчдын захиалгаар Говь-Алтай аймгийн цээл суман дахь “Алтайн хүдэр” ХХК-ийн төмрийн хүдрийн уурхайд задгай эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор, Сэлэнгэ аймгийн Ерөө суман дахь “Болд төмөр ерөө гол” ХХК-ийн төмрийн хүдрийн уурхайд задгай эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн цогцолбор зэрэг томоохон төслүүдийг амжилттай гүйцэтгэсэн юм.

ТЭСРЭХ МАТЕРИАЛ, ХИМИЙН БОДИСЫН ТЭЭВЭРЛЭЛТ

Аюултай ачаа, химийн бодисын тээвэрлэлтийг “Бласт” ХХК-ийн охин компани болох “Бласт Автомотив”ХХК хариуцан ажилладаг.

“Бласт Автомотив”ХХК нь 2011 онд гадаад худалдаа, автомашинаар ачаа тээвэрлэх гэсэн үндсэн чиглэлээр үүсгэн байгуулагдсан бөгөөд, “Аюултай ачаа тээвэрлэх зөвшөөрөл” бүхий бага, дунд, хүнд даацын авто тээврийн хэрэгслээр бусад аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан тэсрэх материал, химийн бодис тээвэрлэх үйлчилгээг үзүүлж байна.

- Нэг удаагийн ачилтаар 1500 тонн хүртэлх ачааг тээвэрлэх хүчин чадалтай.
- Бүх тээврийн хэрэгсэл GPS, сансрын холбоогоор тоноглогдсон.
- ЦЕГ-ын баталсан маршрутын дагуу, дотоодын цэргийн хамгаалалт дор, тэсрэх материалтай харьцах эрх бүхий мэргэшсэн туршлагатай жолооч нар найдвартай, шуурхай хүргэж өгч үйлчилдэг.

САЛБАРУУДЫН ОНЦЛОГ, ГАЗАР ЗҮЙН БАЙРШИЛ



Налайх салбар /Улаанбаатар хот, Налайх дүүрэг/

Савлагаат эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр

Энгийн болон хүчитгэсэн энгийн тэсрэх бодисын үйлдвэр

Нарийн сухайт салбар /Өмнөговь аймаг, Гурвантэс сум/

Задгай эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр

Энгийн тэсрэх бодисын үйлдвэр

Таван толгой салбар /Өмнөговь аймаг, Цогтцэций сум/

Задгай эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр

Энгийн тэсрэх бодисын үйлдвэр

Шивээ-Овоо салбар /Говьсүмбэр аймаг, Шивээ говь сум/

Энгийн тэсрэх бодисын үйлдвэр

ГИШҮҮН БОЛОН ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУД

"ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО"

INTERNATIONAL SOCIETY OF EXPLOSIVES ENGINEERS

МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ЯАМАН

МАК

САУСГОБИ СЭНДС SouthGobi Sands

НАРИЙН СУХАЙТ

BAYALAG ENERGY RESOURCE

БАЯН АЙРАГ ЭКСПЛОРЭЙШН ХХК

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР"ХХК

MONGOLROSTSVETMET

TSAIRT "TSAIRT MINERAL" LLC

MONMAG

МТЭ

MB

ИСКРА НОВОСИБИРСКИЙ МЕХАНИЧЕСКИЙ ЗАВОД

БОЗ

avgroup

TREAD CORPORATION

Nelson Brothers LLC

MAXAM

ROTHENBUHLER ENGINEERING

MREL GROUP OF COMPANIES

976-11-325995, 330116
976-11-330117
info@blastcompany.mn
www.blastcompany.mn
Бласт ХХК
Улаанбаатар хот-14253, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Чингисийн өргөн чөлөө-13, Ландмарк оффис 3 давхарт

/// доорх.төрлөх.хүрээлэн